



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 57

Мандалговь

Хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Байгууллагын батлагдсан төсөвт зардлаас 300,000 /гурван зуун мянган/ төгрөгт багтаан принтер бэлтгэхийг аймгийн Уламжлалт анагаах ухааны төвд зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгийг зохих хууль журмын дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг Уламжлалт анагаах ухааны төв /Х.Чирчинсүрэн/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100134